

**НИЙСЛЭЛИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН ЛАБОРАТОРИ 23 ДУГААР
СУРГУУЛИЙН МОНГОЛ ХЭЛ БИЧГИЙН БАГШ БАЙВАЛ ОВОГТОЙ
АЛТАНЦЭЦЭГИЙН 2018-2019 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

1. Төлөвшил

1. Олон нийтийн үйл ажиллагаанд оролцсон байдал: 1.Гадаад хэлний баярт ангийн сурагчид үндэсний хувцсаар ижилсэн оролцож, шинээр монгол хятадын төрийн далбаатай болсон,мөн монгол үндэсний иж бүрэн хувцас хийлгүүлэв..



2. Гэгээн зөн” яруу найргийн наадамд анги хамт олноороо монгол бие биелгээгээрээ амжилттай оролцлоо.



- 3.”Ангийн дарга нарын зөвөлгөөн”-д ангийн дарга Маргад-Эрдэнэ,Номин-Эрдэнэ нар хэлэлцүүлэг явуулж өөрсдөдөө тулгамдаж буй асуудлыг илрүүлэн илтгэл тавьсан.


4. ХГҮА-ны цагаар сурлага хүмүүжил,дэг хэрэгжилтийн талаар ярилцаж хэвшсэн .

Дэгийн хэрэгжилт, дадал хэвшил суусан байдал:

Судалгааны дүгнэлт			
СДҮА	Иргэний боловсрол	АЧСҮА	ХГҮА
Агуу ЛГҮН ХҮРЭ Э	-Өөрийн ёс суртахуун, дадал хэвшил төлөвшихтэй холбогдох харилцаа, хандлага -Бусад хүмүүс, хамт олон, нийгэмтэй зохистой харилцах, хандах -Монгол ёс заншил, аж төрөх ёс, соёлтой холбогдох харилцаа хандлага -Байгальтай зүй зохистой харилцах харилцаа, хандлага	-Сурагчийн хэрэгцээ сонирхолд үндэслэсэн сонгох сэдвүүд (ажил мэргэжил, гэр бүл, хүний амь нас, байгалийн зохицол сонин содон үзэгдэл) -Сургууль орон нутаг, улс орны онцлог, хэрэгцээнд тулгуурласан сонгох сэдвүүд (сургуулийн дэг, соёл, аюулгүй орчин, орон нутгийн хүмүүс болон байгууллага, орон нутгийн уламжлал, соёл, аюулгүй хот, дүүрэг, сум, баг) -нийтлэг сэдвүүд (эрүүл мэнд,хоол хүнс, орон сууц, шинжлэх ухаан, технологийн хөгжил, үр дүн бидний амьдралд)	-Өөрийн авьяас чадварыг хөгжүүлэхтэй холбоотой үйл ажиллагаа - Суралцах арга барилыг сайжруулахтай холбоотой үйл ажиллагаа -Ангийн үйл ажиллагаа (ангийн зорилго,зохион байгуулалт, анги хамт олны уур амьсгал, эв нэгдлийг бэхжүүлэхтэй холбоотой үйл ажиллагаа, Хувь сурагчийн нэр хүнд, эрүүл мэнд, аюулгүй байдалтай холбоотой үйл ажиллагаа)
Үйл явц	Ёс суртахуунлаг зан чанар нь ёс суртахуунлаг зүрх сэтгэлээр дамжин ёс суртахуунлаг шийдвэр гаргах чадвар, ёс суртахуунлаг шийдвэрээ үндэслэн ёс суртахуунлаг үйлдэл хийх чадвар,	Суралцагч бодит үйл ажиллагаанд оролцох явцдаа эрэл хайгуул хийх, асуудал олж харах, эргэцүүлэн бодох, дүгнэх, асуудлыг илүү сайнаар шийдвэрлэх арга барил, чадварт суралцана. Суралцагч эрэл хайгуулын явцад	Боловсролын талаарх төрийн бодлого, сургуулийн зорилго, орон нутаг, сургууль хүүхдийн бодит байдал, хөгжил, хэрэгцээ, эцэг эх, багшийн хүсэлд тулгуурлан түүнийг дэмжсэн байдлаар төлөвлөгдөж хэрэгжинэ. Бүх төрлийн хичээл, иргэний

1.Хичээл эхлэхээс 15-20 ийн өмнө гадаа жагсаж ангийн тугаар бүрэн ирцтэй ордог болсон нь хичээлээс хоцрохгүй 100% хоцролтгүй хамт олон боллоо.

3. **Бусадтай харилцах байдал** : Анги танхим ,сургууль олон нийтийн газарт биеэ зөв авч явах бусадтай зөв харилцах,ахмадыг хүндэтгэх тал дээр байнга зөвлөж ирсэн.
4. Бусадтай харилцах зан чанар :7-р ангийн бүлэг хоорондын нөхөрлөлийг эвээр болон зарим сурагчидтай /хааяа эцэг эхтэй нь хамтдаа /ганцаарчилан уулзаж АУБ-тай тохиролцон
5. **Сурагчдын оролцооны ур чадварын хөгжил, дадал хэвшил зан чанарын байдал** :
6. . ХГҮА-ны цагаар хүүхдүүд маш өгөөжтэй байлгахад ихээхэн анхаарч ажилласан нь үр дүнтэй болсон.
7. Жижүүр багшийн үнэлгээ: жижүүр багшийн үүрэгт ажлыг 4 удаа сайн гүйцэтгэсэн .
1. **Хэдэн судалгаа хийсэн, ямар үр дүнд хүрсэн эсэх, ажилласан байдал** :
2. Хувь хүүхдийн авьяас чадварын судалгаанд а. IQ хөгжүүлэх-9, б. Хэл сурах - , в. Сагсан бөмбөг -5 , г. Волейбол -8 , д.хөл бөмбөг -11 , е. Уран бичлэг болон монгол бичиг -8 , ё. Зураг урлал -9 , ж. Усан спорт -15 , з.Робот -5 и. Ширээний теннис -5 гэж гарлаа .
3. . Хүүхдүүд амжилттай сурч эцэг эхдээ тайлан тавьсанд эцэг эх сэтгэл ханамжтай байлаа
4. Эцэг эхээс хүүхдийн унших чадварын судалгаа авсан бөгөөд цаашид энэ тэлаар ажил явуулахаар төлөвлөн ажиллаж байгаа



5. Ангийн сурагчдын өндөр жингийн судалгаа хийсэн.Сургуулийн эмч И.Соёлмаа,мэдээлэлзүйн багш Оюунгэрэл нартай хамтран ширээний ард зөв суун хараагаа хэрхэн хамгаалах вэ ,хэрхэн алдаагүй зөв бичих вэ хичээлийг хамтран заалаа
6. **Дадлага удирдах ажлын үр дүн** : МУИС эх хэл бичгийн ангийн оюутан Б.Мөнхтуяа багшлах дадлага 8 долоо хоног,мөн МУБИС ийн монгол хэлний багшийн ангийн 2 оюутны ажиглах дадлага 4 долоо хоног үргэлжлэн удирдав.Энэ хугацаанд нэгж боловсруулалт,хичээл заалт, дүнтэй цаг заалт, багшийн бичиг баримтын бичилт хийлт, хяналтын ажлын боловсруулалт,засалт,анализ ,танхимын бус ажил үүргийн биелэлт түүний тайлан бичилт зэрэгт дагуулан сургалаа.ЗАН-ээрээ тайланг хэлэлцэж тодорхойлолт бичин үнэлгээ өглөө.
8. **Эцэг эхийн оролцоо, хичээлээс гадуурх хүмүүжлийн ажлын үр дүн** : 1. “Эцэг эхийн зөвөлгөөн”-д сурагч Мишээлийн ээж Мөнхцэцэг эцэг эхийн төлөөлөл болж илтгэл тавьсан..2.Эцэг эхчүүдэд зориулсан Мүүдлийн сургалтанд 2 аав,1 ээж хамрагдан ангийнхаа эцэг эхчүүдэд сургалт явуулав 3. Ангийн эрүүл аюулгүй орчны бүрдүүлэх, ариун цэврийн жсуудлыг шийдэж цэвэрлэгээний материал авч өгсөн. 4.Гадаад хэлний баярын тоглолтыг хоёр өдрийн турш зохион байгуулалтанд ажиллаж дэмжлээ.

Эцэг эхийн дунд сурган хүмүүжүүлэх мэдлэг шалгах судалгаа авч үр дүнг тооцож ажиллалаа

9. **Хүүхэд хамгааллын ёс зүйн дүрмийн биелэлт:** НА Г.Эрдэнэчимэгтэй хийсэн хүүхэд хамгааллын ёс зүйн дүрмийн дагуу танхимын болон танхимын бус үйл ажиллагааг явуулж гуравласан гэрээг дүгнэж ажиллалаа.
10. **Гранд дизайны зорилго зорилтын биелэлт :** 1. Хүүхэд нэг бүрийн хөгжлийг дэмжсэн үйл ажиллагаанд тэгш хамруулсан. 2. Зөв дадал хэвшилд уриалсан санал зөвлөмжөөр хангасан.3. Зөв хандлагад чиглүүлсэн сонирхол өрнөхүйц мэдээ мэдээллээр ханган ажилласан.3. Багаар болон бие даан асуудал шийдвэрлэх ур ухаанд хөтөлсөн.4. Цагийг үр дүнтэй ,зөв хуваарилалттай



ажиллаж сурахад ХГҮА-ны цагийг төлөвлөсөн.5. Дугуйлан секцэд олон сурагч хамрагдсан.. 6. Өөрийн биеэр үлгэрлэн аливааг хамтран хийх зэрэг оролдлогын дүнд а.Цаг баримталдаг ХҮҮХЭД б.Бусдыг сонсдог ХҮҮХЭД в. Чин сэтгэлээсээ ханддаг ХҮҮХЭД г.Зөв дадал хэвшилтэй ХҮҮХЭД д.Авьяас,сонирхол,ур чадвараа нээсэн,сурах эрмэлзэлтэй ХҮҮХЭД болон хүмүүжиж байна. Аав ээждээ захидал бичиж өөрсдийн гараар бэлэг дурсгалын зүйл урлаж өглөө.



2. Мэдлэг чадвар ахиц, амжилт

1. Гарааны болон Оношлох үнэлгээ :
2. Улирал бүрийн нэгж хичээлийн боловсруулалт /MOODLE/ 1. 3-р улиралд 3 нэгж 2. 4-р улиралд 5 нэгж боловсруулан СА-р батлуулан Мүүдлд оруулсан.
3. Стандарт хэрэгжилт

ЧД-ийн 23-р сургуулийн 2018-2019 оны хичээлийн жилийн 7,9 дүгээр ангийн сурагчдын НЭГДҮГЭЭР улирлын үнэлгээний дүгнэлт

ЧД-ийн 23-р сургуулийн 2018-2019 оны хичээлийн жилийн 7,9 дүгээр ангийн сурагчдын НЭГДҮГЭЭР улирлын үнэлгээний дүгнэлт

№	Хичээл орсон анги	Заадаг хичээлийн нэр	Дүгнэгдэх сурагчийн тоо	Дүгнэгдсэн сурагчийн тоо	Үр дүнгийн үнэлгээний түвшин							
					VIII	VII	VI	V	IV	III	II	I
1	7д	Монгол хэл	56	56	29	18	4	3	2			
2	7д	Уран зохиол	56	56	56	0	0	0	0			
3	7д	Үндэсний бичиг	56	56	25	14	17	0	0			
4	7е	Монгол хэл	56	56	23	21	5	7	0			
5	7е	Уран зохиол	56	56	31	20	3	2	0			
6	7е	Үндэсний бичиг	56	56	33	19	3	1	0			
7	9г	Монгол хэл	43	43	15	20	6	2	0			
8	9г	Уран зохиол	43	43	32	6	2	3	0			
9	9г	Үндэсний бичиг	43	43	28	5	6	4	0			
10	9д	Монгол хэл	46	46	15	21	9	1	0			
11	9д	Уран зохиол	46	46	35	6	2	3	0			
12	9д	Үндэсний бичиг	46	46	23	17	2	4	0			
НИЙТ			603	603	345	167	59	30	2			0

ЧД-ийн 23-р сургуулийн 2018-2019 оны хичээлийн жилийн 7,9 дүгээр ангийн сурагчдын ХОЁРДУГААР улирлын үнэлгээний дүгнэлт

ЧД-ийн 23-р сургуулийн 2018-2019 оны хичээлийн жилийн 7,9 дүгээр ангийн сурагчдын ХОЁРДУГААР улирлын үнэлгээний дүгнэлт

№	Хичээл орсон	Заадаг хичээлийн нэр	Дүгнэгдэх сурагчийн	Дүгнэгдсэн сурагчийн	Үр дүнгийн үнэлгээний түвшин							
					VIII	VII	VI	V	IV	III	II	I
1	7д	Монгол хэл	56	56	23	26	7	0	0	0	0	0
2	7д	Уран зохиол	56	56	30	21	5	0	0	0	0	0
3	7д	Үндэсний бичиг	56	56	24	24	8	0	0	0	0	0
4	7е	Монгол хэл	56	56	25	25	6	0	0	0	0	0
5	7е	Уран зохиол	56	56	31	20	5	0	0	0	0	0
6	7е	Үндэсний бичиг	56	56	36	19	0	1	0	0	0	0
7	9г	Монгол хэл	42	42	31	11	0	0	0	0	0	0
8	9г	Уран зохиол	42	42	26	14	2	0	0	0	0	0
9	9г	Үндэсний бичиг	42	42	27	13	2	0	0	0	0	0
#####	9д	Монгол хэл	44	44	44	0	0	0	0	0	0	0
	9д	Уран зохиол	44	44	44	0	0	0	0	0	0	0
	9д	Үндэсний бичиг	44	44	29	15	0	0	0	0	0	0
НИЙТ			594	594	370	188	35	1	0	0	0	0



Нэгдүгээр улирал болон хоёрдугаар улирлын үнэлгээний түвшинг харьцуулан авч үзвэл хоёрдугаар улиралд суралцагчдын үнэлгээ ахисан түвшин гарч байна.

Өөрийгөө хөгжүүлэх төлөвлөгөөний биелэлт :

1. Мүүдлийн сургалтанд хамрагдан шалгалтаа 87 хувьтай өгсөн . 2. Сурагч бүрийг “Тэргүүний уншигч” болгох зорилго тавин судалгаа хийж ажилласан.
3. Монгол бичгийн дүүргийн хурдан уншигч уралдаанд 7д анги сургуулийс шалгаран дүүрэгт амжилттай оролцсон.. 4. Залуу багш нарыг аливааг цаг хугацаанд нь бүрэн гүйцэтгэж сурахад чиглүүлэх, үлгэрлэн үзүүлэх, дагуулан сургах үйлийн зорилгоо биелүүлж байгаа. 5. “Нэг сурагч-нэг ном” хөтөлбөр хариуцан сургуулийн номын санд ном хандивласан. 6. Цэнэглэх цаг бүрийн үр ашигтай зөвлөмж, санааг тусган хэрэгжүүлж байгаа.
4. Судлагдахууны хөтөлбөрийн үр дүн : 7г, 7д, ангийн-177 сурагчид хөтөлбөр төлөвлөгөөний дагуу сургалтын үйл ажиллагаагаа хэвийн явууллаа.
5. Журнал бичилт: Сургалтын үйл ажиллагааны явц суралцагчдын оролцоо, хичээлээр эзэмшсэн мэдлэг чадварын түвшин, ахиц, өөрчлөлт, үр дүнг тэмдэглэн хөтөлсөн. .
6. Хичээлд ордог сурагчдын хүртээмж: 7д, 7е бүлгийн нийт 112 сурагчид монгол хэл бичиг уран зохиолын хичээл орж байна.
7. . Долоо хоног бүр 350-531 дэвтэр шалгаж, монгол бичгийн хичээлийн шинэ үсэг үг өгүүлдэрийг байнга бичиж өгч дагуулан сургаж байв.
8. Багшийн хөгжлийн дэвтрийн хөтлөлт: БХД-н үзүүлэлт бүрээр, өдөр тутам хийх ажил болон хийгдсэн хамрагдсанг дэлгэрэнгүй бичиж СА-аар дүгнүүлж байсан

9. Хүүхэд бүрийн ахиц амжилтанд нөлөөлсөн бүтээлч ажил:

Сурагч бүрийг үнэн зөв үнэлэхийн тулд хосоор ажиллах аргыг үнэлгээний зарчимд тулгуурлан хийж байсан.

10. Сурагчдын сурах үйлд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэж байгаа байдал :
1.Бага ангиас дунд ангид шилжин суралцаж буй 6 дугаар ангийн сурагчдын хувьд ачаалал даах чадвар сул ,дадал болоогүй ,бие даах чадвар төдийлэн сайн биш зэрэг байдал ажиглагдлаа.
11. АУБагшийн хувьд боломжоороо бүх мэргэжлийн багшийн хичээлд нь сууж багш нартай нь ангийн сурагчдын тухай ганцаарчлан ярих, эцэг эхээс хүүхдийн онцлог зан чанар, ажиллах арга,авьяасыг мэдэж авах замаар нэлээд ойлголцол бий болгож чадлаа.

3. Авьяасыг нээн судлах хөгжүүлэх

7. Сонирхлын судалгаа хийсэн.Авьяаслаг –23 урлагийн наадамд анги хамт олноороо оролцож “7дугаар ангиудын шилдэгийн шилдэг анги” суурь боловсролын дэд байрыг тус тус эзлэв. Хүүхэд бүрийг хамруулж чадсан төдийгүй шинээр цөөхүүл хөгжмийн хамтлагтай болов..Сургуулийн шинэ жилээр шилдэг ханын сонины уралдаанд тэргүүн байр эзэлсэн.
8. **Дугуйлан секцэд хамрагдсан сурагчдын судалгаа** /танхим ба танхимын бус/ :2018-2019 хичээлийн жилд бг ангийн сурагчид давхардсан тоогоор 176 дугуйлан,секц,сургалтанд хамрагдлаа. Үүнд . IQ хөгжүүлэх-7, б. Хэл сурах -12 в. Сагсан бөмбөг -2, г. Волейбол 3 , д.хөл бөмбөг -3 , е. Уран бичлэг болон монгол бичиг -8 , ё. Зураг урлал -6, ж. Усан спорт -13 , з.1 и..Ширээний теннис-9 й. Загвар, хувцас зохион бүтээх-3 сурагчид дээрх чиглэлээр дугуйланд хамрагдсан байна..
9. **Ангийн номын сангийн баяжилт** : Ангийн сурагчид хятад хэл дээр бичигдсэн ном солилцон уншсан.
Сургуулийн номын санд хүүхэд бүр ном хандивласан..
10. Уншсан номын тэмдэглэл хөтөлсөн эсэх : 1.”Амьдрах сайхан шүү”Аялагч Амайд захидал сэтгэгдэл захиа 2. Уншсан номын тэмдэглэл хөтлөв.
11. **Бүтээлийн үзэсгэлэн гаргасан байдал** :
.“Улаанбаатар номын баяр”-т оролцон бүх хэвлэлийн газрын энэ жилийн хэвлэсэн номтой танилцан сонирхолтой номыг худалдан авч хамтран ажиллав. 203 тоот монгол хэлний танхимд монгол бичгийн үзэсгэлэн гаргасан.
12. **Хүүхэд нэг бүрийг хөгжүүлсэн байдал** /Улс нийслэл, дүүрэг, сургууль/

Б.Тэмүүлэн өсвөр үеийн боксын улсын аваргаас 3 медаль,Сурагч Эрхэмбаяр гар зургийн улсын уралдаанаас тусгай байр,СурагчБ.Санчирмаа гар зургийн улсын уралдаанд тусгай байр ,Сурагч Б.Энхзаяа улсын шигшээ багийн сагсан бөмбөгийн тамирчин болж ОХУд болсон тэмцээнээс алтан медаль,хэлний улсын олимпиадад зохион бичлэгийн болон ярианы төрөлд гутгаар байр,

Авьяаслаг 23 урлагийн наадмын тусгай байр,сургуулийн ханын сонины уралдаанд шалгарсан.



13. Олимпиад уралдаан тэмцээн :



14. Хятад хэлний сургалттай “9 д анги”Чингэлтэй дүүргийн монгол хэлний анги нийтийн олимпиадад”Тэргүүн байр”

15. Нийслэлийн монго хэлний олимпиадад 10дугаар байр тус тус эзлэв.

Нийслэлийн монгол хэлний олимпиадад 7 д ангийн сурагч Б.Пүрэвдолгор хүрэл медаль

Дүүргийн Монгол бичгийн хурдан уншлагын уралдаанд 7д анги амжилттай оролцов.



Бүтээлч ажил

МоЗан хамт олон заах аргын нэгдлүүдийг сонгон авч монгол бичиг заан сургасан. Миний хувьд **Англи хэлний заах аргын нэгдлийн** багш нарт монгол бичиг зааж, багш нартай хамтран хичээнгүй бичгийн үзэсгэлэн гаргав .9 дүгээр ангийн сурагчдындунд”Миний мэдэх-Монголын нууц товчоо”сэдэвт эвхмэл угалзан бийрийн болон дүрслэг бичээсээр шигтгээ, даавуун ,зээгт наамал эсгий урлалын бүтээл хийж сургуульдаа бүтээлийн үзэсгэлэн гаргав. 9дүгээр ангийн сурагчид дэлхийн яруу найрагчдын өдрөөр хүүхдийн төв номын санд зохиолчидтой уулзалт,ярилцлагад оролцов.

4. Чингэлтэй дүүргийн багш нартай хамтран судалгаат хичээлийг 3 удаа хамтран явуулсан.
5. Мэргэжлийн зэргээ ахиулж "Тэргүүлэх" зэрэгт шалгуулж тэнцэв..

4. Боловсролын сэтгэл ханамж

1. Цаг ашиглалт : 1. Дэвтэртэй ажиллах, даалгаврыг нэг бүрчлэн шалгах 2. Журналт бичилт хийх 3. Багшийн хөгжлийн дэвтэр хөтлөх 4. Хичээл заах 5. Цаг үеийн хурал ,цуглаанд хамрагдах 6. Ангиа тараах 7. Ангиа цэвэрлүүлэх 7. Хяналтын ажил засах 8. Олимпиад уралдаан тэмцээн явуулах, засах 8. Анги болон сурагчдаа үйл ажиллагаанд бэлдэх 9. Цаг үеийн сургуулийн үйл ажиллагаанд оролцох 9. Багш нарын хичээлд суух, хэлэлцүүлэх зохион байгуулах 10. Сурагчдад эерэг болон хэрэгцээт сургалт /танхимын бус/ явуулах 11. Хүүхдийн сурах эрүүл ,аюулгүй орчин бүрдүүлэх 12. Эцэг эхийн хурал зохион байгуулах, судалгаа авах 13. Мүүдлийн сургалтанд хамрагдах 14. Сурагчдыг хичээлээс гадуурх үйл ажиллагаанд хамруулан үзвэр үйлчилгээ үзүүлэх, сэтгэгдэл бичүүлэх 15. Жижүүр багш хийх 16. 6-р ангийн бүлгийн ажил ,хуралд хамрагдах 17. ЗАН-ийн хурал болон цаг үеийн ажилд хамрагдах 18. Ангийн эд аж ахуйн эвдрал засах, будах шинэчлэх 19. Ангиа шалгалт шүүлэгт бэлдэх 20. Нэгжийн болон улирлын шалгалт авч засах дүнг оруулах 21. Сурагч бүрийн хувийн хэрэгтэй танилцан хөтлөлт хийх 22. Ямар нэг судалгаа авч нэгтгэх, явуулах 23. Дадлага удирдах ,сургах, дадлагын хэлэцүүлэг хийх 24. Төгсөгч сурагчидтай харилцах ,тодорхойлолт бичих, тэдэнд үйлчлэх

Сэтгэл ханамжийн судалгаа : 1. Эцэг эхээс сургуулийн үйл ажиллагааны сэтгэл ханамжийн судалгаа авч бүлгээр нэгтгэн өгсөн


2. **Хичээлийн цагийн хариуцлага**-40 минут : Хичээлийн цагийн алдагдалгүй ажилласан.
3. **Багшийн ёс зүй, хууль эрх зүйн биелэлт** : Тухайн анги ,сурагчдын нас биений онцлог зан аашны өөрчлөлтийг ШУ-ны үүднээс судалж тохирсон аргаар нь харьцан ёс зүйг дээдлэн сэтгэл ханамжтай ажиллалаа.
4. **Багшийн хичээлийн бэлтгэл** : 1. Улирал бүрийн нэгж хичээлийн хөтөлбөр боловсруулан СА-р батлуулж байсан. Нийт 36 нэгж батлуулсан. 2. Мүүдл системд 11 нэгж хөтөлбөрөө оруулсан. 3. Амралтын даалгавар боловсруулан өгч сурагч нэг бүрийн амралтын даалгаврыг шалган эцэг эхэд нь мэдээлсэн. 4. Цөм хөтөлбөрийн ном болон бдугаар ангийн сурах бичгээ ашигласан.. 5. Нэг бүлэгт 2-3 багш орохдоо нэгнийхээ боловсруулсан хөтөлбөр, төлөвлөгөөг хамтран хэлэлцэж сайжруулах, туршин заах ,хэлэлцүүлэгт хичээл явуулах зэрэг ажил хийгдэж байгаа нь заах арга зүйн хувьд хамтаараа сайжрах боломжтой болсон
5. **Хоцрогч таслагч сурагчидтай ажилласан байдал хүрсэн үр дүн** : 6-р ангийн сурагчид хичээл тасалдаггүй байдалд хэвшсэн.
6. **Багш сургалтын ажлын баримт бичгийг зохих журмын дагуу хөтөлж байгаа байдал** : 1. Багшийн журналыг бүрэн бичилт хийж 2. Анги журналыг үзүүлэлт бүрээр 3. Багшийн хөгжлийн дэвтрийг өдөр тутам хөтлөн 4. Сурагчийн хувийн хэргийн зөв хөтлөлтийг шалган дутууг гүйцээх зэргийг заагдсан хугацаа бүрд нь СА-р үнэлүүлж хэвшсэн.
7. **Сургалтын техник хэрэгслийг ашигласан байдал** : 1. Өөрийн нөөтбүүк дээр шаардлагатай программ ашиглан боловсруулалт хийж сурсан. . 2. Ангийн зурагтыг НДМ оролтоор холбон "Мүүдэл"-ээс хэрэгтэй материалаа татан "Цахим" орчин үүсгэн хэрэглэж сурсан.

8. **Боловсролын шинэчлэл, "Цөм хөтөлбөр"-ийг чанартай хэрэгжүүлж, хамт олонтойгоо эерэг уур амьсгалаар харьцаж, мэргэжлийн багийн үйл ажиллагаанд идэвх санаачилгатай оролцсон. Удирдлагуудын өгсөн үүрэг даалгаврыг цаг тухайд нь чанартай биелүүлсэн. Багшийн ёс зүйн дүрмийг баримтлан ажилласан.**

Сургуулийн удирдлага болон заах аргын нэгдлээс өгсөн үүрэг даалгаврыг тогтмол, цаг хугацаанд нь, чанартай хийж гүйцэтгэсэн. Сургууль болон дүүргээс зохиож байгаа тэмцээн уралдаанд идэвхтэй оролцоно. . НБГ-ын болон бусад сургалт семинарт тогтмол хамрагдаж, сурсан мэдсэн зүйлээ цаг хугацаа алдалгүй ажил хэрэг болгосон. Багшийн ёс зүйн алдаа гаргалгүй хамт олон, сурагч, эцэг эхтэйгээ хамтран ажилласан.Сургуулийн удирдлагын зүгээс багш нарын саналыг хүлээн авч хамтран ажиллаж байгаад талархаж байгаа болно

5. Эрүүл мэнд

1. **Мэндлэх хүндлэх –Зөв боловсон харилцаа** :Нийт сурагчид зөвхөн хичээл ордог багшийг таньдаг тэдэнтэй мэндэлдэг зэрэгт суурилан сургуулийн бүх багш нар,ажилчидтай мэндлэх,хүндлэх монгол ёсоо хэвшүүлэхзорилгоор 2сарын хугацаанд өглөө мэндлэх аянд санаачлагатай оролцож, зохих үр дүнд хүрсэн гэж үзэв.



2. **Эрүүл мэндийн анхан шатны дадал хэвшилд сургаж үлгэрлэсэн байдал** : 1. Дөрөвдүгээр цагийн завсарлагаанаар хичээл орж буй ангитайгаа Гимнастик хийж хэвшсэн. 2. Зөв суух дадалд хичээл ордог ангийн сурагчдыг зөв суухын ашиг тусыг ШУ-ны үндсийгтаниулан зөвлөн хичээл бүр дээр сануулан ажиллаж байна. Сургуулийн эмчтэй хамтран ажиллав.
3. 3.Ангийн сурагчдыг улирал бүр салаа хооронд байрлалыг солих, өдөр бүр урагш ахих замаар байрыг солин харааны нэг өнцөг тогтохоос сэргийлэн ажиллаж байна.
4. **Эрүүл мэндийн сургалт зохион байгуулж гарсан үр дүн**: 1. Өндөр жингийн индекс гарган жингийн илүүдэлтэй болон дутагдалтай сурагчдыг илрүүлэн ЭЭХ-р хувьчлан мэдээлэл хүргүүлж урьдчилан сэргийлэх ажил болгов. 2. “Улаанбурхан”өвчний мэдээллийг интернетээс авч зөв таниулга хийн ангийн 59 сурагчийг хамруулав.
5. **Анги танхимын цэвэр эмх цэгцтэй байдалд сургаж хэвшүүлсэн байдал** :1. Анги даан авахад ангийн самбарын доор байрлах шүүгээ арийун цэврийн шаардлага хангахгүй бохир байсан, анги цэвэрлэх материалыг хадгалах боломж байхгүй, хүүхдийн эрүүл,аюулгүй орчин бүрдээгүй зэргийн ЭЭЗ-тэй ярилцаад дараах байдлаар шийдвэрлэлээ. 2. Сурагч өөрийн сууж буй орчинг

6. Эрүүл орчинд байхын ач тусын талаар ойлголт өгч хэвшүүлэв.
7. . 2. Агаар дуслын замаар халдварлаж болох өвчний талаар 1-р баг “Сүрьеэ” өвчний талаар РРТ бэлдүүлэн ангид мэдээлэл хүргэн хэрхэн өөрсдийгөө эрүүл авч явах талаар ойлголттой болсон. 3. Их завсарлагаанаар цайлсаны дараа дараа гар угааж Санитол тогтмол хэрэглэх . 4. Агаар цэвэршүүлэгчийг тогтмол ажиллах горимын дагуу нь сурагч Нандин-Эрдэнэ хариуцан ажилладаг болсон.
8. Жижүүр сурагчдын үйл ажиллагаа жигд ажиллагаатай эсэх : 1. Анги цэвэрлэх материал нь хүүхдийн аюулгүй байдалд нийцүүлэн бүрэн болгосон. 2. Гуравдугаар улирлаас смен ангиа 3. Тав дах өдөр бүр салаа бүрээр ангиа угаалгаж яаж цэвэрлэх талаар өөрөө хамтран хийж хэвшсэн. 4. Сар бүр “Их цэвэрлэгээ” хийж гол нь ширээ сандлын хөлөнд наалдсан буртгийг цэвэрлүүлж сургаж.
9. **Анги танхимын эд хөрөнгийн ашиглалт хамгаалалтын талаар зөв ойлголт өгч, тэдгээртэй зөв харилцах дадал хэвшилд сургасан байдал** : Сурагч Азжаргал Бат-Эрдэнэ нар эд аж ахуй эвдрэлийг тухай бүрд нь засах баг болон ажиллаж хэрэгтэй эрэг ,боолтыг ангидаа / эцэг эхээр бэлдүүлэн / бэлэн байлган ажиллаж байна.
10. **Эрүүл мэндийн үзлэг, сургалт өвчлөлөөс урьдчилан сэргийлэх талаар хийж хэрэгжүүлсэн байдал** : 1. “Улаанбурхан” вакцин 2. “Сүрьеэ”-гийн сорил 3. Вирусын гаралтай ханиаднаас сэргийлэх санамж зөвлөгөөг өгсөн. 4. Өндөр жингийн индексийг гарган зөв хоололтын РРТ танилцууланв. 5. Гараа тогтмол угаах,санитол ариутгагч хэрэг боломж бүрдүүлэн ажилласан.
11. **Ангийн ариун цэвэр эрүүл мэндийн булангийн хэрэгжилт**: Ангийн ариун цэврийн даргаар сурагч Г.Буян-Ундрах ажиллан ханын шүүгээнд ширээний болон шалны хувин,ширээ ханын болон шалны алчуурыг тусад нь угааж дэлгэн хатааж хадгалдаг болсон . Мөн угаалгын нунтаг, резинэн бээлийн 3ш ,ширээ болон шал угаах щётка 2ш ,гарын шингэн саван,гар ариутгах Санитол, цонх шил арчих элгэн алчуур ,шил угаах цацагч шингэн үүдний хөлийн гишгүүр,шалны мод зэрэг материалыг ЭЭЗ-өөр шийдүүлсэн.
12. **Эрүүл шүд-Эрүүл хүүхэд үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн хүрээнд хийсэн ажил** : Эцэг эхэд эрүүл ахуйн болон шүдний эрүүл ахуйн талаар зөвлөгөө өгсөн.

Тайлан бичсэн.Монгол хэлбичгийн багш Б.Алтанцэцэг